



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Дүүргийн 2013-2016 оны "Цахим засаглал" хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцээд дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д ДААЛГАХ нь:

1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, төрөөс үзүүлж буй үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй болгох зорилгоор мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүхий цахим системд суурилсан үйлчилгээг эрчимжүүлж, иргэд байгууллагад хүргэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдээс төрийн захиргааны байгууллага руу хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгох.

2. Төрийн байгууллагуудад интернетэд суурилсан дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, бичиг хэрэг хөтлөлтийн нэгдсэн програм хангамжийн стандартыг бий болгох замаар ажлын уялдааг сайжруулах.

3. Дүүргийн иргэдийн цахим боловсролыг дээшлүүлж, олон нийтэд зориулсан утасгүй интернетийн цэгүүдийн тоог нэмэгдүүлэхэд аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах.

4. "Цахим засгалал"-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн явц, үр дүнг хагас жил тутам дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулах.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хог хаягдал гаргасны төлбөр хураамжийн  
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12/45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй албан байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр үйлчилгээний газрын хог хаягдал гаргасны сарын төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан төлбөр хураамжийг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Хог хаягдал гаргасны төлбөр хураамж шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 22 дугаар тогтоолыг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



Аж ахуй нэгж байгууллагын хог хаягдал гаргасны  
сарын төлбөрийн хэмжээ

Д/д	Аж ахуй нэгж байгууллагын төрөл	Хог хаягдал гаргасны сарын төлбөр хураамж /төгрөг/	Тайлбар
<b>1</b>	<b>Нэг. Нийтийн хоол, зочид буудал, аялал жуулчлалын байгууллагууд:</b>		
<b>1.1</b>	<b>Зоогийн газар, ресторан, кафе, цайны газар:</b>		
	50 хүртэлх суудалтай	60000	
	100 хүртэлх суудалтай	80000	
	100 дээш суудалтай	200000	
<b>1.2</b>	<b>Бар, караоке, диско клуб, шөнийн цэнгээний газар:</b>		
	50 хүртэлх суудалтай	90000	
	100 хүртэлх суудалтай	105000	
	100 дээш суудалтай	200000	
<b>1.3</b>	<b>Зочид буудал:</b>		
	16 хүртэлх ортой	55000	
	17-30	80000	
	31-с дээш	100000	
<b>2</b>	<b>Хоёр. Худалдаа, ахуйн үйлчилгээний салбарууд:</b>		
<b>2.1</b>	<b>Дэлгүүр:</b>		
	Зуны түр худалдаа	30000	
	ТҮЦ	23000	
	8 нэрийн хүнсний дэлгүүр	50000	
	24 цагийн	90000	
	Павилон, Алт мөнгөний, 6 нэрийн дэлгүүр	30000	
	Супермаркет	300000	
	Их дэлгүүр	1500000	1 лангуу-10000,
	Хүнс барааны зах	1500000	Павилон
	Бөөний худалдааны төв	1500000	5м2 хүртэлх - 10000, 5.1м2-аас дээш - 20000 тооцно
	Барааны дэлгүүр	40000	
	Гэр ахуй болон мебелийн дэлгүүр	97500	
	Билльярд, теннис, РС тоглоомын газар	35000	
	Сэлбэгийн дэлгүүр	35000	
<b>2.2</b>	<b>Ахуйн үйлчилгээний газрууд:</b>		
	Үсчин, гоо сайхны салон	36000	Суудлын тооноос хамаарч 1 суудал 12000
	Зурагчин	30000	
	Саун массаж	45000	
	Халуун ус	50000	
	Гутал засвар	20000	
	Алт мөнгөний дархан	25000	
	Түүхий эд хүлээн авах цэг /шил бусад/	45000	
	Шатахуун түгээх станц	40000	
	Нотариат, Ломбард	15000	
	Ил задгай худалдаа эрхлэгчдэд	15000	
	Канон, компьютер, интернэйт	20000	
	Дугуй засвар	25000	
	Машин угаалга /төвлөрсөн/	50000	

	Авто засварын газар	75000	
	Хими цэвэрлэгээ	40000	
	Оёдол, эсгүүр, хувцас захиалга	25000	
	Шуудан холбооны салбар	50000	
<b>3</b>	<b>Гурав. Боловсролын салбар:</b>		
	Их дээд сургууль	130000	
	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ясли	100000	
	Жолооны сургууль	40000	
	Төрөл бүрийн сургалт	30000	
	Номын сан	25000	
<b>4</b>	<b>Дөрөв. Эрүүлийг хамгаалах салбар:</b>		
	Эмнэлэг (ортой)	650000	
	Эмнэлэг (оргүй)	150000	
	Өрхийн эрүүл мэндийн төв	30000	
	Эмийн сан (энгийн)	45000	
	Эмийн сан /24/	65000	
	Эм ханган нийлүүлэх төв	95000	
<b>5</b>	<b>Тав. Үйлдвэрлэлийн байгууллага:</b>		
	Жижиг (5-10 хүнтэй)	67500	
	Дунд (11-20 хүнтэй)	112000	
	Том (21-ээс дээш)	270000	
	Хиамны цех	75000	
	Ундаа зайрмагны үйлдвэр	102000	
	Гурилан бүтээгдэхүүн	102000	
	Хэвлэлийн үйлдвэр	102000	
<b>6</b>	<b>Зургаа. Бусад:</b>		
	Банк, банк бус санхүүгийн байгууллага	150000	
	Оффис 1мкв	1000	1 м2 тутамд - 1000



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

「Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх」  
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдэд  
урамшуулал олгох тухай

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдэд сар бүр мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Урамшууллын хэмжээг сар бүр 40000 төгрөгөөр тооцож, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас улиралд нэг удаа олгож байхыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/ -д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

«Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр»  
ажиллах хүний тоо, урамшууллын  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд туслах чиг үүрэг бүхий хэв журмын урамшилтай эргүүлийг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хороо бүрт ажиллуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллах хүний тоог 22, урамшууллын хэмжээг сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хүртэл байхаар тогтоосугай.

3. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, хороодод ажиллах эргүүл, жижүүрийн тоог хоёрдугаар хавсралтаар, ажил дүгнэх үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Энхдөлгөөн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 03 сарын 28-ны  
өдрийн 4 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



## ХОРООДОД АЖИЛЛАХ ХЭВ ЖУРМЫН УРАМШИЛТАЙ ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий хэв журмын урамшилтай эргүүл /цаашид эргүүл гэх / -ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эргүүл нь үйл ажиллагаандаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хууль, “Захиргааны хариуцлагын тухай” хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Эргүүл нь хорооны салбар зөвлөлийн даргын шууд удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хорооны цагдаагийн хэсгийн байцаагч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.4. Эргүүл нь тухайн хорооны нутаг дэвсгэрт байнга оршин суугч, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байна.

1.5. Эргүүлээр ажиллах иргэнийг тухайн хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн саналыг үндэслэн дүүргийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлөх бөгөөд хорооны ГХУСАЗ салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газартай гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

### Хоёр. Эргүүлийн үйл ажиллагааны зорилго, үндсэн чиг үүрэг

2.1. Эргүүл нь тухайн хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангуулах, энэ чиглэлээр төр, захиргаа, хууль хяналтын байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

2.2. Эргүүл нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас гаргасан хууль тогтоомж, дүрэм журмыг иргэд олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдийн дунд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Гэмт хэрэг болон нийгмийн хэв журмын зөрчлийг цагдаагийн байгууллага болон холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;

2.2.3. Тухайн хорооны гэмт хэргийн шалтгаан нөхцөл, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж, талбай, аж ахуйн нэгж байгууллагуудад хэсэгчилсэн байдлаар тандалт хийж, эргүүлийн үүргийг тогтмол гүйцэтгэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах;

2.3. Журмаар тогтоосон чиг үүргээ гүйцэтгэхдээ хороо, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, холбогдох байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авах эрхтэй;

2.4. Эргүүл нь хүн саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоох, иргэний биед болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг хурааж авах, хууль хяналтын байгууллагын нэр барих, цагдаагийн албан хаагчийн хувцас форм өмсөх, тусгай хэрэгсэл /гав, бороохой зэрэг/ ашиглах, албан үүргийн дагуу олж авсан хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд дэлгэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусад субъектэд өгөхийг тус тус хориглоно.

### **Гурав. Эргүүлийн үйл ажиллагааны баталгаа, урамшуулал, хариуцлага**

3.1. Эргүүлд журмаар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө сар бүр мөнгөн урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээ, ажиллах хүний тоог дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

3.2. Эргүүл нь ажлаа батлагдсан ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр дүгнүүлэн сар бүрийн 25-ны дотор ажил дүгнэсэн үзүүлэлтийг илтгэх хуудсийн хамт дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ирүүлнэ.

3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эргүүлийн ажил дүгнэсэн үзүүлэлтийг нэгтгэн илтгэх хуудсын хамт дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанд танилцуулан урамшууллын шийдвэрийг гаргуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.4. Эргүүлийн мөнгөн урамшууллыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас санхүүжүүлнэ.

3.5. Эргүүл нь үнэмлэх, таних тэмдэг бүхий энгэрийн тэмдэгтэй байна.

3.6. Эргүүл нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийгмийн баталгааг эдэлнэ.

3.7. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн эргүүлийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 03 сарын 28-ны  
өдрийн 4 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ХОРООДОД АЖИЛЛАХ ХЭВ ЖУРМЫН УРАМШИЛТАЙ  
ЭРГҮҮЛИЙН ТОО

д/д	Хороод	Эргүүлээр ажиллах хүний тоо
1	1 дүгээр хороо	1
2	2 дугаар хороо	1
3	3 дугаар хороо	1
4	4 дүгээр хороо	1
5	5 дугаар хороо	1
6	6 дугаар хороо	1
7	7 дугаар хороо	2
8	8 дугаар хороо	1
9	9 дүгээр хороо	1
10	10 дугаар хороо	1
11	11 дүгээр хороо	1
12	12 дугаар хороо	2
13	13 дугаар хороо	1
14	14 дүгээр хороо	1
15	15 дугаар хороо	1
16	16 дугаар хороо	1
17	17 дугаар хороо	1
18	18 дугаар хороо	1
19	19 дүгээр хороо	2
Нийт	19	22

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 03 сарын 28-ны  
өдрийн 48 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



Хороодод ажиллах хэв журмын урамшилтай эргүүлийн  
ажил дүгнэх үзүүлэлт

д/д	Ажил дүгнэх үзүүлэлт	0-20 оноо	Тайлбар
1	Ажилласан цаг, цаг ашиглалтын байдал		
2	Гэмт хэрэг, зөрчлийн талаар хууль хяналтын байгууллагад мэдээлж ажилласан байдал		
3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цаг үеийн ажилд идэвхи, санаачлагатай оролцсон байдал		
4	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр гудамж, талбайд эргүүл хийсэн байдал		
5	Хорооны салбар зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүн		
	Нийт		

Дүгнэсэн: Хорооны салбар зөвлөлийн дарга: ..... /

/

Эргүүлүүдэд хийсэн ажлын үр дүнг харгалзан урамшууллыг үзүүлэлтийн дагуу 100 хүртэлх оноогоор дүгнэж олгоно.

91-100 оноо 100%

81-90 оноо 90%

61-80 оноо 80%

50-60 оноо 50%-ийн урамшуулал тус тус олгогдоно.

49%-иас доош оноогоор үнэлэгдсэн тохиолдолд урамшуулал олгохгүй.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг  
эрчимжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь хэсгийг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүрэгт 2014 онд Орон нутгийн хөгжлийн сангийн болон дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг календарчилсан төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг холбогдох хууль журамд нийцүүлэн иргэдийн оролцоотой зохион байгуулж, үр дүнг тооцон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

“МОНГОЛ УЛСЫН УРЛАГИЙН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-ООР

- |                     |   |
|---------------------|---|
| 1. Батмөнхийн Мушка | Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны өндөр настан |
|---------------------|---|

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ГООР

- |                        |  |
|------------------------|--|
| 1. Хайдавын Гомбосүрэн | Нийслэлийн Тээврийн газрын Ахмад ажилтан |
|------------------------|--|

“ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ГООР

- |                         |   |
|-------------------------|---|
| 1. Дарьжавын Цагаанцоож | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны өндөр настан |
|-------------------------|---|

“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

- |                           |  |
|---------------------------|--|
| 1. Дашдэндэвийн Уранчимэг | “Холч ирээдүйн замчин” ХХК-ийн захирал   |
| 2. Цэмбэлдоржийн Энхтуяа  | “Тавин ус” ХХК-ийн захирал   |
| 3. Ламжавын Дуламсүрэн    | “Бичигтэй” ХХК-ийн оёдолчин, эсгүүрчин   |
| 4. Олзонгийн Эрдэнэцэцэг  | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч |

- |                              |  |
|------------------------------|--|
| 5. Очирбатын Цэцэгмаа        | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч |
| 6. Санжжавын Цэрэннадмид     | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны өндөр настан                              |
| 7. Сүрэнхорын Хишигбаяр      | “Алтан эрхэст од” ХХК-ийн нягтлан бодогч                                       |
| 8. Санжаасүрэнгийн Түмэнцэнд | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны өндөр настан, Ахмадын зөвлөлийн дарга     |
| 9. Мунаагийн Нямдорж         | “Сансар кабель” ХХК-ийн орлогын байцаагч                                       |
| 10. Балжингийн Энхбат        | “Сансар кабель” ХХК-ийн аж ахуйн дарга   |
| 11. Ягааны Жавзандолгор      | “Сансар кабель” ХХК-ийн нягтлан бодогч   |
| 12. Тэрбишийн Туяа           | “Урт цагаан” ХХК-ийн оёдолчин  |

**“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР**

- |                                |   |
|--------------------------------|---|
| 1. Ганшинбалын Цэвээндулам     | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан, “Байгаль эх таны төлөө” ТББ-ын гишүүн |
| 2. Гэндэнжамцын Гэрэлмаа       | Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг хөтөлбөрийн менежер                           |
| 3. Чойсүрэнгийн Цэцэгмаа       | Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн “Гэр бүл” эмнэлэгт бага эмч                |
| 4. Пүрэвсүрэнгийн Баасан       | “Мөнгөн сүлд” ХХК-ийн дэлгүүрийн эрхлэгч  |
| 5. Намхайжанцангийн Өнөржаргал | Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн гэмтлийн эмч                                  |
| 6. Аюурзанын Амаржаргал        | “Сансар кабель” ХХК-ийн нягтлан бодогч  |

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

┌ Буцалтгүй тусламж олгох тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн Цэрэннадмид овогтой Сүхбаатарын хүү Амартүвшин нь хүнд өвчний улмаас гадаад улсад яаралтай мэс заслын эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд нь туслах зорилгоор нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Буцалтгүй тусламж олгоход шаардагдах зардал 1000000 (нэг сая) төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (Ц.Алтанцацрал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ